



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 27 өдөр

Дугаар A/482

Улаанбаатар хот

Г Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.20.7, 19.21, 19.22, Эрүүл мэндийн яамны “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, түдгэлзүүлэх байгууллагын нэрсийг хоёрдугаар, хүчингүй болгох байгууллагын нэрсийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ




Эрүүл мэндийн сайдын 2017 оны
12 сарын 07 өдрийн дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НЭМЭЛТЭЭР ОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Жаргалант-Эрдэнэ ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	Ай энд эр Монголия ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Эрч спортс ХХК	биологийн идэвхт бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
4	Хүслэн од констракшн ХХК	ариутгах, халдвартгүйжүүлэх бодис импортлох, ханган нийлүүлэх	3 жил
5	Оюут фарм ХХК	эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
6	Эм би жи ХХК	гэмтэл согог, сэргээн засах, мэс засал, дотор, нүүр амны мэс заслын тусlamж үйлчилгээ	3 жил
7	Сонрисас ХХК	нүүр амны тусlamж үйлчилгээ	3 жил
8	Оргил рашаан сувилал ХХК	сувиллын тусlamж үйлчилгээ	3 жил
9	Сөүл сениорс товер ХХК	Төрөлжсөн мэргэшлийн тусlamж үйлчилгээ /мэс засал/	3 жил
Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох байгууллага			
1	Монсан медикал сервис ХХК	эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11. сарын 27-ны өдрийн
A/482 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
1	Юу Би Өү Эс Эс Ти И Эм ХХК	/Клиник/ нүүр амны өвчний тусlamж үйлчилгээ	3 сар



Эрүүл мэндийн сайдын
2017 оны 11. сарын 27. -ны өдрийн
A/482 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл
1	Оргил рашаан сувилал төрийн өмчийт хувьцаат компани	Сувиллын тусlamж үйлчилгээ
2	Ачит Арвис ХХК	Нүүр амны өвчний тусlamж үйлчилгээ
3	Перфект ХХК	Клиник, Биохимиийн лабораторийн тусlamж үйлчилгээ
4	Сөүл сениорс товер ХХК	Төв эмнэлгийн тусlamж үйлчилгээ